



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/144/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2025 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a>  Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a>  Аудитыг гүйцэтгэсэн: Ари файнэнс аудит ХХК-ийн Захирал: Д.Ариунаа Утас: 99088151 Цахим хаяг: <a href="mailto:arifin.audit@gmail.com">arifin.audit@gmail.com</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
4. Аудитын тайлан .....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. Аудитын илрүүлэлт .....	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	19

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ШУ	Шинжлэх ухаан
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗҮҮНБҮРЭН  
СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Х.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

2025-02-25 № 10А-2025/144/МА-СТА-7113  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэг нь үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 91.1 хувьтай тайлагнагдсан.

### Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус газрын тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 6 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

432502239

## **Бусад асуудлын хэсэг**

Тус цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93.3 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс ны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>164,877,443.85</b>	<b>175,140,900.91</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>129,420,349.72</b>	<b>95,881,959.73</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>129,420,349.72</b>	<b>95,881,959.73</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>129,420,349.72</b>	<b>95,881,959.73</b>
31211	Төрийн сангийн харилцах	129,420,349.72	95,881,959.73
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>570,052.22</b>	<b>1,147,639.33</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	570,052.22	1,147,639.33
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>34,887,041.91</b>	<b>78,111,301.85</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>34,887,041.91</b>	<b>78,111,301.85</b>
35410	Бичиг хэргийн материал	924,287.00	1,384,787.00
35420	Аж ахуйн материал	18,565,999.91	61,375,759.85
35450	Барилгын засварын материал	2,876,000.00	2,876,000.00
35470	Бусад хангамжийн материал	12,474,755.00	12,474,755.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>738,065,843.16</b>	<b>748,884,184.24</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>738,065,843.16</b>	<b>748,884,184.24</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>728,670,509.72</b>	<b>739,572,184.08</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	719,586,305.14	719,306,305.06
39202	Хуримтлагдсан элэгдэл	(78,023,064.84)	(95,732,722.44)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	81,907,248.00	81,907,248.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,124,430.80)	(24,722,303.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	64,691,102.86	64,691,102.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	(41,194,927.80)	(13,544,918.76)
39209	Зам, гүүрийн байгууламж	1,084,000.00	1,084,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(722,666.88)	(559,999.80)
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,234,713.00	13,234,713.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,293,884.96)	(6,617,356.20)
39217	Ном	526,116.00	526,116.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>9,395,333.44</b>	<b>9,312,000.16</b>
39301	Програм хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(166,666.56)	(249,999.84)
39303	Бусад биет бус хөрөнгө	9,312,000.00	9,312,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>902,943,287.01</b>	<b>924,025,085.15</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,634,150.00</b>	<b>2,082,131.05</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,634,150.00</b>	<b>2,082,131.05</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>1,634,150.00</b>	<b>2,082,131.05</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	308,138.20
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	648,992.85
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>1,634,150.00</b>	<b>1,125,000.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	1,634,150.00	1,125,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>901,309,137.01</b>	<b>921,942,954.10</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>901,309,137.01</b>	<b>921,942,954.10</b>

**Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	202,588,074.46	202,588,074.46
51101	Өмч: - төрийн	202,588,074.46	202,588,074.46
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>211,208,819.33</b>	<b>231,842,636.42</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	211,208,819.33	222,128,819.25
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	9,713,817.17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	487,512,243.22	487,512,243.22
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>902,943,287.01</b>	<b>924,025,085.15</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>836,202,611.80</b>	<b>997,411,928.31</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>58,540,400.00</b>	<b>96,953,071.60</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>58,540,400.00</b>	<b>96,953,071.60</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.0	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	35,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	58,540,400.00	56,192,311.66
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	0.0	40,725,759.94
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>777,662,211.80</b>	<b>900,458,856.71</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>724,306,900.00</b>	<b>839,434,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	724,306,900.00	839,434,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>53,355,311.80</b>	<b>61,024,456.71</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	53,355,311.80	61,024,456.71
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>697,314,388.78</b>	<b>976,778,111.22</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>697,314,388.78</b>	<b>976,778,111.22</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>697,314,388.78</b>	<b>976,778,111.22</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>454,035,039.91</b>	<b>683,104,636.64</b>
210101	Үндсэн цалин	339,727,439.11	449,483,479.49
210102	Нэмэгдэл	101,105,952.80	207,618,277.15
210104	Урамшуулал	13,201,648.00	26,002,880.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>57,735,437.17</b>	<b>84,042,434.44</b>
210201	Тэтгэврийн даатгал	39,735,832.24	57,419,859.74
210202	Тэтгэмжийн даатгал	4,674,803.86	6,755,752.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,811,088.15	3,408,907.41
210204	Ажилгүйдлийн даатгал	847,690.81	3,228,413.75
210205	Эрүүл мэндийн даатгал	8,666,022.11	13,229,500.63
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>49,885,311.80</b>	<b>58,203,449.56</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,354,530.41	10,279,692.85
210302	Түлш, халаалт	39,426,181.39	46,598,356.71
210303	Цэвэр, бохир ус	1,104,600.00	1,325,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>77,672,110.00</b>	<b>78,675,830.00</b>
210502	Хоол, хүнс	77,672,110.00	78,675,830.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>594,000.00</b>	<b>3,030,500.00</b>
210604	Урсгал засвар	594,000.00	3,030,500.00

**Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,174,800.00</b>	<b>2,301,140.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,174,800.00	2,301,140.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>56,217,689.90</b>	<b>67,420,120.58</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,360,780.00	16,207,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,463,350.00	5,838,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,393,559.90	45,373,970.58
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>138,888,223.02</b>	<b>20,633,817.09</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>29,249,856.72</b>	<b>10,919,999.92</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	29,249,856.72	10,919,999.92
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)</b>	<b>(29,249,856.72)</b>	<b>(10,919,999.92)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>109,638,366.30</b>	<b>9,713,817.17</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>777,662,211.80</b>	<b>900,493,856.71</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.0</b>	<b>35,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>0.0</b>	<b>35,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.0	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	35,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>777,662,211.80</b>	<b>900,458,856.71</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>724,306,900.00</b>	<b>839,434,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	724,306,900.00	839,434,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>53,355,311.80</b>	<b>61,024,456.71</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгуудлага/	53,355,311.80	61,024,456.71
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>667,164,568.10</b>	<b>934,032,246.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>667,164,568.10</b>	<b>934,032,246.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>667,164,568.10</b>	<b>934,032,246.70</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>454,605,092.08</b>	<b>683,311,386.17</b>
210101	Үндсэн цалин	337,521,107.83	454,731,883.64
210102	Нэмэгдэл	104,220,251.06	203,642,119.93
210104	Урамшуулал	12,863,733.19	24,937,382.60
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>57,735,437.22</b>	<b>84,105,133.82</b>
210201	Тэтгэврийн даатгал	39,735,832.29	57,326,523.33
210202	Тэтгэмжийн даатгал	4,674,803.86	6,755,752.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,811,088.15	3,408,907.40
210204	Ажилгүйдлийн даатгал	847,690.81	3,267,237.43
210205	Эрүүл мэндийн даатгал	8,666,022.11	13,346,712.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>49,885,311.80</b>	<b>57,554,456.71</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,354,530.41	9,630,700.00
210302	Түлш, халаалт	39,426,181.39	46,598,356.71
210303	Цэвэр, бохир ус	1,104,600.00	1,325,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>77,718,110.00</b>	<b>78,629,830.00</b>

**Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210502	Хоол, хүнс	77,718,110.00	78,629,830.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,470,000.00</b>	<b>3,470,000.00</b>
210604	Урсгал засвар	3,470,000.00	3,470,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,174,800.00</b>	<b>2,301,140.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,174,800.00	2,301,140.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>22,575,817.00</b>	<b>24,660,300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,617,630.00	18,182,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,958,187.00	6,478,300.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>110,497,643.70</b>	<b>(33,538,389.99)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>110,497,643.70</b>	<b>(33,538,389.99)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		129,420,349.72
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	129,420,349.72	95,881,959.73

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	202,588,074.46	487,512,243.22	211,208,819.33	901,309,137.01
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.0	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	202,588,074.46	487,512,243.22	211,208,819.33	901,309,137.01
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.0	0.00
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	202,588,074.46	487,512,243.22	211,208,819.33	901,309,137.01
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	202,588,074.46	487,512,243.22	211,208,819.33	901,309,137.01
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	10,919,999.92	10,919,999.92
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	202,588,074.46	487,512,243.22	222,128,819.25	912,229,136.93
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	9,713,817.17	9,713,817.17
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	202,588,074.46	487,512,243.22	231,842,636.42	921,942,954.10

**Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,025,152,600.00</b>	<b>934,032,246.70</b>	<b>91,120,353.30</b>	<b>91.1</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,025,152,600.00</b>	<b>934,032,246.70</b>	<b>91,120,353.30</b>	<b>91.1</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,025,152,600.00</b>	<b>934,032,246.70</b>	<b>91,120,353.30</b>	<b>91.1</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>761,673,200.00</b>	<b>683,311,386.17</b>	<b>78,361,813.83</b>	<b>89.7</b>
210101	Үндсэн цалин	525,550,500.00	454,731,883.64	70,818,616.36	86.5
210102	Нэмэгдэл	221,676,000.00	203,642,119.93	18,033,880.07	91.9
210104	Урамшуулал	14,446,700.00	24,937,382.60	(10,490,682.60)	172.6
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>89,534,100.00</b>	<b>84,105,133.82</b>	<b>5,428,966.18</b>	<b>93.9</b>
210201	Тэтгэврийн даатгал	60,884,700.00	57,326,523.33	3,558,176.67	94.2
210202	Тэтгэмжийн даатгал	7,161,300.00	6,755,752.91	405,547.09	94.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,581,300.00	3,408,907.40	172,392.60	95.2
210204	Ажилгүйдлийн даатгал	3,581,300.00	3,267,237.43	314,062.57	91.2
210205	Эрүүл мэндийн даатгал	14,325,500.00	13,346,712.75	978,787.25	93.2
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>58,465,900.00</b>	<b>57,554,456.71</b>	<b>911,443.29</b>	<b>98.4</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,630,700.00	9,630,700.00	-	100.0
210302	Түлш, халаалт	47,509,800.00	46,598,356.71	911,443.29	98.1
210303	Цэвэр, бохир ус	1,325,400.00	1,325,400.00	-	100.0
2105	<b>Нормативт зардал</b>	<b>82,630,800.00</b>	<b>78,629,830.00</b>	<b>4,000,970.00</b>	<b>95.2</b>
210502	Хоол, хүнс	82,630,800.00	78,629,830.00	4,000,970.00	95.2
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,470,000.00</b>	<b>3,470,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210604	Урсгал засвар	3,470,000.00	3,470,000.00	-	100.0
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,449,100.00</b>	<b>2,301,140.00</b>	<b>147,960.00</b>	<b>94.0</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,449,100.00	2,301,140.00	147,960.00	94.0
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>26,929,500.00</b>	<b>24,660,300.00</b>	<b>2,269,200.00</b>	<b>91.6</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,451,200.00	18,182,000.00	2,269,200.00	88.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,478,300.00	6,478,300.00	-	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,025,152,600.00</b>	<b>900,493,856.71</b>	<b>124,658,743.29</b>	<b>87.8</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>839,434,400.00</b>	<b>839,434,400.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	839,434,400.00	839,434,400.00	-	100.0
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>61,935,900.00</b>	<b>61,024,456.71</b>	<b>911,443.29</b>	<b>98.5</b>
132001	Орон нутгийн төсвөөс	61,935,900.00	61,024,456.71	911,443.29	98.5
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>123,782,300.00</b>	<b>35,000.00</b>	<b>123,747,300.00</b>	<b>0.0</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	35,000.00	(35,000.00)	

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан					
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	123,782,300.00		123,782,300.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		129,420,349.72	(129,420,349.72)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		95,881,959.73	(95,881,959.73)	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэхэд оршино” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд цэцэрлэгтээ айдасгүй, амар тайван суралцаж, суралцахуйн хоцрогдолгүйгээр эрүүл, аюулгүй, тэгш хүртээмжтэй орчинд сурч хөгжих боломжийг бүрдүүлэх
- Багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан тасралтгүй хөгжих олон хувилбарт сургалт үйл ажиллагааг зохион байгуулж менежментийг сайжруулах
- Багш ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээ шаардлагыг мөрдөж, төсвийг төлөвлөх үр ашигтай зарцуулахад идэвх санаачилгатай оролцох

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн;
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

**Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсвийн төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй, шинээр гарсан хууль тогтоомж, дүрэм, журмын өөрчлөлтийг тусгах шаардлагатай байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21,081.8 мянган төгрөгөөр өссөн дүнтэй байна.

#### **Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	129,420.3	95,881.9	(33,538.4)
Авлага	570.1	1,147.6	577.5
Бараа материал	34,887.0	78,111.3	43,224.3

**Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Үндсэн хөрөнгө	738,065.8	748,884.2	10,818.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>902,943.2</b>	<b>924,025.0</b>	<b>21,081.8</b>
Өр төлбөр	1,634.1	2,082.1	448.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	901,309.1	921,942.9	20,633.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>902,943.2</b>	<b>924,025.0</b>	<b>21,081.8</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл мянган төгрөг болж 95,881.9 мянган төгрөг болж 33,538.4 мянган төгрөгөөр буурсан нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх “Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас шалтгаалсан байна.
- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 95,881.9 мянган төгрөг болж 33,538.4 мянган төгрөгөөр буурсан нь Төсвийн тухай хуулийн 7.9-д заасны дагуу гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжсэнээр төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 78,111.3 мянган төгрөг болж 43,224.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 101,212.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн Боловсролын газраас 17,600.0 мянган төгрөгийн хүүхдийн хичээлийн хэрэглэгдэхүүн, Зүүнбүрэн сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 23,125.8 мянган төгрөгийн зөөлөн эдлэл үнэ төлбөргүй хүлээн авсан, 98,714.0 мянган төгрөгийн бараа материалын зарцуулсантай холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 748,884.2 мянган төгрөг болж 10,818.4 мянган төгрөгөөр өссөн нь 56,192.3 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж, ашиглалтын хугацааг сунгасан, 45,373.9 мянган төгрөгийн элэгдлийг нэмж байгуулсантай холбоотой байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус цэцэрлэгийн 2024 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 743,933.1 мянга, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 61,935.9 мянга, нийт 805,869.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжилтийг 3,356.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 809,225.2 мянган төгрөгөөр баталснаас тайлант онд төсөвт

**Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

зохицуулалт хийгдэж улсын төсвөөс 839,434.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 61,935.9 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 123,782.3 мянган төгрөг зэрэг нийт 1,025,152.6 мянган төгрөгөөр баталсан байна.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 839,434.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 61,935.9 мянган төгрөгийг бүрдүүлэхээс улсын төсвөөс 839,434.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 61,024.4 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 35.0 мянган төгрөг, нийт 900,493.8 мянган төгрөг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 934,032.2 мянган төгрөг буюу 91.1 хувьтай байгаа нь хүүхдийн хоолны зардлыг 4,001.0 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 74,865.5 мянган төгрөгөөр, явуулын багшийн үйлчилгээний зардлыг 7,810.7 мянган төгрөгөөр, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардлыг 3,385.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

**Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

*/мянган төгрөгөөр/*

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	<b>Улсын төсвөөс санхүүжих</b>				
1	80233-Хүүхэд хамгаалал	1,055.1	1,055.1	0.0	100.0
2	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,402.8	1,265.0	137.8	98.5
3	81607-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	82,630.8	78,629.8	4,001.0	97.8
4	81816-Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	2,454.0	2,454.0	0.0	100.0
5	81823-Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,408.6	1,400.0	8.6	51.5
6	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	848,516.3	773,650.8	74,865.5	89.4
7	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	9,958.6	6,573.2	3,385.4	86.5
8	81833-Явуулын багшийн үйлчилгээ	15,790.5	7,979.8	7,810.7	0.0
	<b>Дүн</b>	<b>963,216.7</b>	<b>873,007.7</b>	<b>90,209.0</b>	<b>84.1</b>
	<b>Орон нутгийн төсвөөс</b>			0.0	
9	8011-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	61,935.9	61,024.5	911.4	99.9
	<b>Дүн</b>	<b>61,935.9</b>	<b>61,024.5</b>	<b>911.4</b>	<b>99.9</b>
	<b>Нийт дүн</b>	<b>1,025,152.6</b>	<b>934,032.2</b>	<b>91,120.4</b>	<b>91.1</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд 1 төсөл арга хэмжээ санхүүжүүлэхээр 58,063.4 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталсан ба хүүхдийн хоол, хүнсний материал худалдан авахаар 58,063.4 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, тендерийн урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан боловч тендерт оролцогч ирээгүй тул Өгөөж баян уул ХХК, MGL tech ХХК-тай тус тус шууд гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Ари файнэнс аудит” ХХК-ийн аудитор Б.Туяа гүйцэтгэж, захирал Д.Ариунаа анхан шатны чанарын хяналтыг, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ари файнэнс аудит” ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 697,314.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,459.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй уялдуулан албан хэрэг эрхлэх ажлыг цахимаар гүйцэтгэж байгаатай холбогдон бичиг хэргийн зардлыг хэмнэсэн, хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус цэцэрлэг нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг 95.4 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	896.7	1	855.8	95.4
Зөвлөмж	2	-	2	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>896.7</b>	<b>3</b>	<b>855.8</b>	<b>95.4</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 40.9 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж баталгаажуулав. Үүнд:

- Өмнөх оны аудитаар өгөгдсөн багш Номин-Эрдэнээс авах 40.9 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг авлага үүсгэж санхүүгийн тайланд бүртгээгүй.

Аудитаар нийт 6,297.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 1,737.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 577.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 3,982.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

1. Сэлэнгэ аймгийн Боловсролын газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн А/32 дугаар тушаалаар цэцэрлэгийн эрхлэгч Х.Өлзийсайханд сахилгын шийтгэл ногдуулсан боловч ур чадварын нэмэгдэлд 1,737.0 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", БШУС, ХНХ, СС-ын сайдын 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/35, А/10, 9 дугаар хамтарсан тушаалын 3 дахь "Багш ажилтанд ур чадварын нэмэгдэл олгоход дараах нийтлэг шалгуурыг харгалзана" 3.2: "Ёс зүйн зөрчилгүй, сахилгын шийтгэлгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ур чадварын нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5.2 Албан шаардлага

1.Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 577.5 мянган төгрөгийн НДШ-ийн авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

## 5.3 Зөвлөмж

### 1. Бараа материалын данстай холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн 3,982.5 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ.” 14.4.1: “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5:“бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бүртгэлд бүрэн тусгаж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмнөх оны аудитаар өгөгдсөн багш Номин-Эрдэнээс авах 40.9 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг авлага үүсгэж санхүүгийн тайланд бүртгээгүй.	1	40.9			1	40.9	1	40.9				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>40.9</b>			<b>1</b>	<b>40.9</b>	<b>1</b>	<b>40.9</b>				

**Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цэцэрлэгийн эрхлэгч Х.Өлзийсайханд сахилгын шийтгэл ногдуулсан боловч ур чадварын нэмэгдэл олгосон.	1	1,737.0	1	1,737.0								
Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас НДШ-ийн авлага үүсгэсэн.	1	577.5			1	577.5						
Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн бараа материалыг орлогоор бүртгэж нягтлан бодох бүртгэлд тусгаагүй.	1	3,982.5					1	3,982.5				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>6,297.0</b>	<b>1</b>	<b>1,737.0</b>	<b>1</b>	<b>577.5</b>	<b>1</b>	<b>3,982.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 159/А.1850385  
100-2025/144/НА-СТАТУС

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 577.5 мянган төгрөгийн НДШ-ийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10: Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол", 4.2.1.11: "Хууль тогтоомж, ... зөрчсөн ..." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийг зохистой удирдаагүйгээс авлага үүсгэсэн зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх
2. Цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Х.Өлзийсайхан, нягтлан бодогч Ц.Уянга нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР



Ч.ЭНХТУЯА  
Д.АРИУНАА

432504475



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 61/АБСОЗРТ

Сүхбаатар

1077-2025/144/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Сэлэнгэ аймгийн Боловсролын газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн Б/32 дугаар тушаалаар эрхлэгч Х.Өлзийсайханд сахилгын шийтгэл ногдуулсан атал ур чадварын нэмэгдэлд 1,737.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" БШУС,ХНХ, Сангийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/35, А/10, 9 дугаар хамтарсан тушаалын 3 дахь "Багш ажилтанд ур чадварын нэмэгдэл олгоход дараах нийтлэг шалгуурыг харгалзана" 3.2: "Ёс зүйн зөрчилгүй, сахилгын шийтгэлгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-т "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. 4.2.3.2: Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- Ур чадварын нэмэгдэлд олгосон 1,737.0 мянган төгрөгийг Сэлэнгэ аймгийн төрийн сан дахь нэр зааж ангилагдаагүй бусад орлогын 100130000955 дугаар дансанд төвлөрүүлэх.
- Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Х.Өлзийсайхан, нягтлан бодогч Ц.Уянга нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ч.ЭНХТУЯА

Д.АРИУНАА



432505182